НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2024/57/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он


Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер Д.Отгонбаяр
Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Бадамхатан
Утас: 325093 Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn

Аудитор: З.Мөнхзаяа
Утас: 325093 Цахим хаяг:Munkhzayaz@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 365

танай ________ -ны № ________ -т

**НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА О.БАТ-ӨЛЗИЙ ТАНАА**

**Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, гэрчилгээг хүргүүлж байна.**

**Хавсралт 11 хуудастай.**

**ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ**

002032947

D:\Desktop\2024\Word\Явсан бичиг\2024.02.23.SBD HEDS A5 docx

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 02. 23 № 366

танай ____________-ны №_____________-т

НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА О.БАТ-ӨЛЗИЙ ТАНАА

# АУДИТЫН ДҮГНЭЛТ

## Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 847,073.4 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

## Аудитын гол асуудал

D:\Desktop\2024\Word\... 2024.02.23.SBD.HEDS.docx 0020221

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

D:\Desktop\2024\Word\Явсан бичиг\2024.02.23.SBD.HEDS.docx

## 2.Аудит хийсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(төгрөг)*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,761,197,752.15** | **2,546,577,000.32** |
| **33** | **АВЛАГА** | 1,761,197,752.15 | 2,546,577,000.32 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 19,895,963.55 | 532,251,916.00 |
| **335** | **Бусад авлага** | 1,741,301,788.60 | 2,014,325,084.32 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 1,741,301,788.60 | 2,014,325,084.32 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,761,197,752.15** | **2,546,577,000.32** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **170,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 170,000.00 |
| **413** | **Өглөг** | - | 170,000.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 170,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 170,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,761,197,752.15** | **2,546,407,000.32** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,761,197,752.15 | 2,546,407,000.32 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,761,197,752.15 | 2,546,407,000.32 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,585,354,119.89 | 1,741,301,788.60 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 175,843,632.26 | 805,105,211.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,761,197,752.15** | **2,546,577,000.32** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(төгрөг)*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,691,454,643.90** | **2,316,598,466.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **705,910,643.90** | **2,316,598,466.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 705,910,643.90 | 2,316,598,466.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 705,910,643.90 | 2,315,982,800.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 443,993,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 705,910,643.90 | 872,366,800.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | - | 999,623,000.00 |
| 120009 | Бусад орлого | - | 615,666.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,985,544,000.00** | **-** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,985,544,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,985,544,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,515,611,011.64** | **1,511,493,254.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,515,611,011.64** | **1,511,493,254.28** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,500,000.00 | 66,538,395.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,500,000.00 | 66,538,395.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,500,000.00 | 66,538,395.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,511,111,011.64 | 1,444,954,859.28 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 546,351,571.00 | 393,739,434.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 546,351,571.00 | 393,739,434.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,090,964,254.90 | 355,860,800.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,090,964,254.90 | 355,860,800.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 338,329,756.74 | 694,738,959.28 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 338,329,756.74 | 694,738,959.28 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **175,843,632.26** | **805,105,211.72** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **175,843,632.26** | **805,105,211.72** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(төгрөг)*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,082,415,254.90** | **2,316,768,466.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,096,871,254.90** | **2,316,768,466.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,096,871,254.90 | 2,316,768,466.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,096,871,254.90 | 2,315,982,800.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 443,993,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 705,910,643.90 | 872,366,800.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 390,960,611.00 | 999,623,000.00 |
| 120009 | Бусад орлого | - | 785,666.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,985,544,000.00** | **-** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,985,544,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,985,544,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,434,733,975.19** | **3,027,952,870.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,434,733,975.19** | **3,027,952,870.28** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,500,000.00** | **66,538,395.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,500,000.00 | 66,538,395.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,500,000.00 | 66,538,395.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,430,233,975.19** | **2,961,414,475.28** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,445,578,571.00 | 1,377,947,134.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,445,578,571.00 | 1,377,947,134.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,093,400,254.90 | 499,630,800.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,093,400,254.90 | 499,630,800.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 355,789,720.29 | 1,083,220,875.28 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 355,789,720.29 | 1,083,220,875.28 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(352,318,720.29)** | **(711,184,404.28)** |
| 14 | **Бусад эх үүсвэр** | 352,318,720.29 | 711,184,404.28 |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | 352,318,720.29 | 711,184,404.28 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **352,318,720.29** | **711,184,404.28** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 0.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(төгрөг)*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 0.00 | 0.00 | 1,585,354,119.89 | 0.00 | 1,585,354,119.89 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **1,585,354,119.89** | **0.00** | 1,585,354,119.89 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 175,843,632.26 | 0.00 | 175,843,632.26 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **1,761,197,752.15** | **0.00** | 1,761,197,752.15 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **1,761,197,752.15** | **0.00** | 1,761,197,752.15 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -19,895,963.55 | 0.00 | -19,895,963.55 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **1,741,301,788.60** | **0.00** | 1,741,301,788.60 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 805,105,211.72 | 0.00 | 805,105,211.72 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **2,546,407,000.32** | **0.00** | 2,546,407,000.32 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(төгрөг)*

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | **Зөрүү** | **Хувь** |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,816,352,000.00 | 1,444,485,529.00 | **371,866,471.00** | **79.5** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,816,352,000.00 | 1,444,485,529.00 | **371,866,471.00** | **79.5** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 72,700,000.00 | 66,538,395.00 | **6,161,605.00** | **91.5** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 72,700,000.00 | 66,538,395.00 | **6,161,605.00** | **91.5** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 72,700,000.00 | 66,538,395.00 | **6,161,605.00** | **91.5** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,743,652,000.00 | 1,377,947,134.00 | **365,704,866.00** | **79.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,743,652,000.00 | 1,377,947,134.00 | **365,704,866.00** | **79.0** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,743,652,000.00 | 1,377,947,134.00 | **365,704,866.00** | **79.0** |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,816,352,000.00 | 1,444,485,529.00 | **371,866,471.00** | **79.5** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,816,352,000.00 | 1,444,485,529.00 | **371,866,471.00** | **79.5** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,816,352,000.00 | 1,444,485,529.00 | **371,866,471.00** | **79.5** |

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант онд санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлттэй холбоотой хугацаа хэтэрсэн 76,975.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, 770,098.4 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй баталгаажуулаагүй нь | 1 | 847,073.4 | | | 1 | 847,073.4 | | | | | | |
| **Дүн** | 1 | 847,073.4 | | | | **847,073.4** | | | | | | |